

Ариун Сүнсийг сайн мэдээг заах болон, суралцах үед үүргээ гүйцэтгэхэд урих нь

“Нэгэнт тэд [Багш нар] сүнслэгээр суралцахад Ариун Сүнсий гүйцэтгэдэг чухал үүргийг ойлгосон тохиолдолд [тэд] эдгээр үүргийг бүрэн гүйцэлдүүлэхийн тулд Сүнсийг урих бүхнийг хийх шаардлагатай.” *

Багш нар юу хийж чадах вэ?	Багш, суралцагчид юу хийж чадах вэ?
<ul style="list-style-type: none"> • Хувийн зохистой байдлын төлөө чармайх. • “Итгэлийн залбирлыг” (С ба Г 42:14) хийх. • Хичээл бүрд бүрэн бэлтгэлтэй байхыг хичээх. • Суралцагчдынхаа суралцах үйл явцад анхаарал тавих. • Аливаа бусад зүйлд санаа зовохгүй, зүрх сэтгэлдээ тайван байхыг эрмэлзэх. • Эрэлхийлэх даруухан сүнстэй байх. • Суралцагчдыг суралцах явцдаа Ариун Сүнсийг урихад нь урамшуулан дэмжих. 	<ul style="list-style-type: none"> • Судар, бошиглогчдын үгсээс уншиж, заах. • Аврагчийн жишээнд төвлөрч мөн Түүний тухай ярилцаж, гэрчлэлээ хуваалцах. • Сайн мэдээний сургаал, зарчмуудыг энгийн бөгөөд тодорхой арга замаар заах. • Илэрхийлэлт хүлээн авахуйц чимээгүй агшинд тунгаан бодох цаг гаргах. • Тохирох зохистой туршлагуудаасаа хуваалцаж, сургаал, зарчмуудыг гэрчлэх. • Нэг нэгэндээ болон Их Эзэнд хайр, талархлаа илэрхийлэх.

* Сайн мэдээг заах ба судлах нь: Шашны семинар ба институтийн багш, удирдагчдад зориулсан гарын авлага (2012), 11.

